



МОНГОЛ УЛСЫН
ЗАСГИЙН ГАЗАР

УУЛ УУРХАЙ,
ХҮНД ҮЙЛДВЭРИЙН ЯАМ

СТРАТЕГИ БОДЛОГО, ТӨЛӨВЛӨЛТИЙН ГАЗРЫН
ЭДИЙН ЗАСАГ, ХӨРӨНГӨ ОРУУЛААЛТ, СУДАЛГААНЫ ХЭЛТЭС

УУЛ УУРХАЙН САЛБАРЫН 2019 ОНЫ ЭХНИЙ 7 САРЫН СТАТИСТИК МЭДЭЭЛЭЛ

УЛААНБААТАР ХОТ
2019.08.28

УУЛ УУРХАЙН САЛБАРЫН 2019 ЭХНИЙ 7 САРЫН СТАТИСТИК МЭДЭЭЛЭЛ

II. УУЛ УУРХАЙН САЛБАРААС УЛСЫН ТӨСӨВТ ОРУУЛСАН ТАТВАР, ХУРААМЖ

2018 оны жилийн эцсийн байдлаар улсын төсөвт **2,051.5** тэрбум төгрөгийг татвар, хураамж хэлбэрээр төвлөрүүлсэн байна. Үүнээс:

- Алт **80.0** тэрбум төгрөг,
- Нүүрс **910.6** тэрбум төгрөг,
- Цайр **76.9** тэрбум төгрөг,
- Зэс **871.9** тэрбум төгрөг,
- Төмөр **17.1** тэрбум төгрөг,
- Жонш **16.3** тэрбум төгрөг,
- Бусад **78.8** тэрбум төгрөг,

Улсын төсөвт орсон орлогыг өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад **456.3** тэрбум төгрөг буюу **28.6** хувиар өссөн. Үүнээс:

- Алт **31.0 (63.1%)** тэрбум төгрөг,
- Нүүрс **306.8 (50.8%)** тэрбум төгрөг,
- Цайр **13.6 (21.5%)** тэрбум төгрөг,
- Зэс **71.1 (8.9%)** тэрбум төгрөг,
- Төмөр **4.7 (38.6%)** тэрбум төгрөг,
- Жонш **4.0 (32.1%)** тэрбум төгрөг,
- Бусад **25.0 (46.5%)** тэрбум төгрөг.

2019 оны эхний 7 сарын байдлаар улсын төсөвт **1.7** их наяд төгрөг татвар, хураамж хэлбэрээр төвлөрүүлсэн байна. Үүнээс:

- Алт **22.2** тэрбум төгрөг,
- Нүүрс **788.7** тэрбум төгрөг,
- Цайр **53.6** тэрбум төгрөг,
- Зэс **723.1** тэрбум төгрөг,
- Төмөр **14.5** тэрбум төгрөг,
- Жонш **19.0** тэрбум төгрөг,
- Бусад **41.0** тэрбум төгрөг,

Улсын төсөвт оруулсан орлого өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад **321.3** тэрбум төгрөг буюу **24.0** хувиар өссөн байна. Үүнд:

- Нүүрс **230.4 (41.3%)** тэрбум төгрөг,
- Зэс **97.9 (15.7%)** тэрбум төгрөг,
- Төмөр **5.1 (53.8%)** тэрбум төгрөг,
- Жонш **9.3 (96.9%)** тэрбум төгрөг,

Харин дараах ашигт малтмалын татвар, хураамж буурсан үзүүлэлттэй байна. Үүнд:

- Алт **13.8 (38.2%)** тэрбум төгрөг,
- Цайр **1.7 (3.0%)** тэрбум төгрөг.
- Бусад **6.0 (12.8%)** тэрбум төгрөг.

УЛСЫН ТӨСӨВТ ТӨВЛӨРҮҮЛСЭН ТАТВАР, ХУРААМЖ, АШИГТ МАЛТМАЛААР

тэрбум төгрөг

Үзүүлэлт	2018		2019		Өөрчлөлт			
	VII	I-VII	VII	I-VII	(4-2)=?, (4/2)=%	(5-3)=?, (5/3)=%	8	9
1	2	3	4	5	6	7	8	9
Нийт дүн	335.1	1,340.9	348.0	1,662.1	12.9	3.8%	321.3	24.0%
Алт	7.9	36.0	3.0	22.2	-5.0	-62.7%	-13.8	-38.2%
Нүүрс	156.0	558.4	175.2	788.7	19.2	12.3%	230.4	41.3%
Цайр	8.5	55.3	10.1	53.6	1.6	18.9%	-1.7	-3.0%
Зэс	149.6	625.2	144.2	723.1	-5.4	-3.6%	97.9	15.7%
Төмөр	0.8	9.4	2.0	14.5	1.2	2.5 ¹	5.1	53.8%
Жонш	1.3	9.6	3.2	19.0	1.9	2.4 ¹	9.3	96.9%
Бусад	10.9	47.0	10.2	41.0	-0.6	-5.8%	-6.0	-12.8%

Тайлбар: 1 - дахин их

II. АЖ ҮЙЛДВЭРИЙН САЛБАР

II.1. АЖ ҮЙЛДВЭРИЙН САЛБАРЫН ГОЛ НЭР ТӨРЛИЙН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ҮЙЛДВЭРЛЭЛ

2019 оны эхний 7 сарын гүйцэтгэлээр **29.1 сая тн** нүүрс, **782.9 мян.тн** зэсийн баяжмал, **7.6 тн** алт, **3.0 мян.тн** молибдений баяжмал, **73.6 мян.тн** хайлуур жоншны хүдэр, **27.1 мян.тн** хайлуур жоншны баяжмал, **4.7 сая тн** төмрийн хүдэр, **1.8 сая тн** төмрийн хүдрийн баяжмал, **50.3 мян.тн** цайрын баяжмал, **4.0 сая бар** газрын тос, **7.3 мян.тн** катодын зэс тус тус үйлдвэрлэсэн байна.

Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад нүүрс **2.8 сая тн** буюу **10.6** хувь, зэсийн баяжмал **22.6 мян.тн** буюу **3.0** хувь, төмрийн хүдэр **1.3 сая.тн** буюу **38.9** хувь, төмрийн хүдрийн баяжмал **95.7 мян.тн** буюу **5.7** хувь, хайлуур жоншны хүдэр **3.8 мян.тн** буюу **5.4** хувь, цайрын баяжмал **3.5 мян.тн** буюу **7.5** хувь, газрын тос **21.8 мян.бар** буюу **0.6** хувиар тус тус өссөн байна.

Харин алт **1.6 тн** буюу **17.4** хувь, молибдены баяжмал **129.0 тн** буюу **4.1** хувь, хайлуур жоншны баяжмал **13.5 мян.тн** буюу **33.3** хувь, катодын зэс **1.1 мян.тн** буюу **13.0** хувиар тус тус буурсан байна.

№	Бүтээгдэхүүний төрөл	Хэмжих нэгж	2018		2019		Өөрчлөлт				
			VI	I-VI	VI	I-VI	(5-3)=?, (5/3)=%	(6-4)=?, (6/4)=%	7	8	9
1	Уул уурхай, олборлох аж үйлдвэр										
1.1	Нүүрс	мян.тн	2,902.3	26,332.2	4,019.9	29,115.9	1,117.6	38.5%	2,783.7	10.6%	
1.2	Газрын тос	мян.бар	563.5	3,941.2	601.7	3,963.0	38.2	6.8%	21.8	0.6%	
1.3	Зэсийн баяжмал, м/агуулгаараа	мян.тн	110.1	760.3	101.3	782.9	-8.8	-8.0%	22.6	3.0%	
1.4	Молибдений баяжмал, м/ агуулгаараа	тн	470.3	3,137.0	435.8	3,008.0	-34.5	-7.3%	-129.0	-4.1%	
1.5	Алт	кг	2,267.1	9,205.5	2,077.6	7,601.5	-189.5	-8.4%	-1,604.0	-17.4%	
1.6	Төмөр:										
	- Төмрийн хүдэр	мян.тн	792.8	3,372.6	847.4	4,685.6	54.6	6.9%	1,313.0	38.9%	
	- Төмрийн хүдрийн баяжмал	мян.тн	150.7	1,666.8	318.6	1,762.5	167.9	111.4%	95.7	5.7%	
1.7	Хайлуур жонш:										
	- Хайлуур жоншны хүдэр	мян.тн	11.6	69.8	7.7	73.6	-3.9	-33.6%	3.8	5.4%	
	- Хайлуур жоншны баяжмал	мян.тн	8.1	40.6	-	27.1	-8.1	-100.0%	13.5	-33.3%	
1.8	Цайрын баяжмал	мян.тн	7.2	46.8	6.9	50.3	-0.3	-4.2%	3.5	7.5%	
2	Боловсруулах аж үйлдвэр										
2.1	Катодын зэс, 99%	тн	1,184.2	8,365.4	986.3	7,275.2	-197.9	-16.7%	1,090.2	-13.0%	
2.2	Металл бэлдэц	тн	1,546.3	16,789.9	3,191.9	19,263.0	1,645.6	106.4%	2,473.1	14.7%	
2.3	Металл цувимал	тн	1,939.8	18,517.3	2,242.1	18,671.5	302.3	15.6%	154.2	0.8%	

Эх сурвалж: ҮСХ

II.2. АЖ ҮЙЛДВЭРИЙН САЛБАРЫН НИЙТ БҮТЭЭГДЭХҮҮН ҮЙЛДВЭРЛЭЛ

тэрбум төгрөг

Салбар	2018		2019		Өөрчлөлт			
	VII	I-VII	VII	I-VII	(4-2)=?, (4/2)=%	(5-3)=?, (5/3)=%		
1	2	3	4	5	6	7	8	9
Нийт дүн	1,211.6	8,648.6	1,424.5	9,813.8	212.8	17.6%	1,165.2	13.5%
Уул уурхай, олборлох аж үйлдвэр	864.4	6,187.5	1,050.6	7,069.2	186.2	21.5%	881.7	14.3%
Нүүрс олборлолт	210.8	2,155.1	404.7	3,031.6	193.9	91.9%	876.4	40.7%
Газрын тос олборлолт	97.0	621.3	90.1	592.6	-6.9	-7.1%	-28.8	-4.6%
Металлын хүдэр олборлолт	544.0	3,331.6	546.2	3,362.5	2.2	0.4%	30.9	0.9%
Бусад ашигт малтмал олборлолт	12.6	79.4	9.5	82.6	-3.0	-24.1%	3.2	4.0%
Боловсруулах аж үйлдвэр	283.4	1,852.3	297.4	2,061.5	13.9	4.9%	209.2	11.3%

Эх сурвалж: ҮСХ

Аж үйлдвэрийн салбарын нийт үйлдвэрлэл 2019 оны 7 сарын гүйцэтгэлээр **9.8** их наяд төгрөгт хүрч өмнөх оны мөн үеэс **1.2 (13.5%)** их наяд төгрөгөөр өслөө. Үүнд уул уурхай, олборлох аж үйлдвэрийн нийт үйлдвэрлэл **7.1** их наяд төгрөгт хүрч өмнөх оны мөн үеэс **881.7 (14.3%)** тэрбум төгрөгөөр, үүнээс нүүрс олборлолт **876.4 (40.7%)** тэрбум төгрөгөөр, металлын хүдэр олборлолт **30.9 (0.9%)** тэрбум төгрөгөөр өссөн нь голлон нөлөөлсөн. Аж үйлдвэрийн салбарын нийт бүтээгдэхүүн үйлдвэрлэлд Уул уурхай, олборлох салбар **72.0** хувийг эзэлж байна.

II.3. АЖ ҮЙЛДВЭРИЙН САЛБАРЫН БОРЛУУЛСАН БҮТЭЭГДЭХҮҮН

тэрбум төгрөг

Салбар	2018		2019			Өөрчлөлт			
	VII	I-VII	VII	I-VII	Гад-дад	(4-2)=?, (4/2)=%	(5-3)=?, (5/3)=%		
1	2	3	4	5	6	7	8	9	10
Нийт дүн	1,378.1	10,037.0	1,588.4	11,718.6	8,332.9	210.2	15.3%	1,681.6	16.8%
Уул уурхай, олборлох аж үйлдвэр	929.8	6,928.5	1,095.7	8,174.0	7,041.8	165.9	17.8%	1,245.5	18.0%
Нүүрс олборлолт	209.4	2,294.3	365.2	3,073.3	2,797.5	155.8	74.4%	779.0	34.0%
Газрын тос олборлолт	93.5	607.7	82.1	556.7	556.7	-1.4	-12.2%	-51.0	-8.4%
Металлын хүдэр олборлолт	616.0	3,943.2	634.0	4,427.6	3,616.3	17.9	2.9%	484.4	12.3%
Бусад АМ олборлолт	10.8	83.4	14.4	116.4	71.3	3.5	32.5%	3.5	39.7%
Боловсруулах аж үйлдвэр	384.6	2,496.9	416.1	2,858.6	1,291.2	31.5	8.2%	361.7	14.5%

Эх сурвалж: ҮСХ

Аж үйлдвэрийн салбарын борлуулсан бүтээгдэхүүн 2019 оны эхний 7 сарын байдлаар **11.7** их наяд төгрөгт хүрч өмнөх оны мөн үеэс **1.7 (16.8%)** их наяд төгрөгөөр өслөө. Үүнээс уул уурхай, олборлох аж үйлдвэрийн салбарын борлуулсан бүтээгдэхүүн **8.2** их наяд төгрөгт хүрч өмнөх оны мөн үеэс **1.2 (18.0%)** их наяд төгрөгөөр, үүнээс нүүрс олборлолт **779.0 (34.0%)** тэрбум төгрөгөөр, металлын хүдэр олборлолт **484.4 (12.3%)** тэрбум төгрөгөөр тус тус өссөн байна.

Аж үйлдвэрийн салбарын борлуулсан нийт бүтээгдэхүүнээс **8.3 (71.1%)** их наяд төгрөг, уул уурхай, олборлох аж үйлдвэрийн салбарын нийт бүтээгдэхүүнээс **7.0 (60.1%)** их наяд төгрөгийн бүтээгдэхүүнийг гадаад зах зээлд тус тус борлуулсан байна.

III. ГАДААД ХУДАЛДАА

Гадаад худалдааны нийт бараа эргэлт 2019 оны эхний 7 сарын байдлаар **8.1** тэрбум ам.долларт хүрч өнгөрсөн оны мөн үеийнхээс **696.4 (9.4%)** сая ам.доллараар өссөн байна. Экспорт импортоос давамгайлж экспорт, импортын зөрүү **1.1** тэрбум ам.доллараар эерэг гарсан байна.

3.1. ЭКСПОРТ

Экспорт **4.6** тэрбум ам.долларт хүрч өнгөрсөн оны мөн үеийн гүйцэтгэлээс **454.8 (11.0%)** сая ам.доллараар өссөн байна. Төмрийн хүдэр, чулуун нүүрс, зэсийн баяжмал, цайрын баяжмал, жонш, молибдений баяжмал, боловсруулаагүй нефть зэрэг уул уурхайн бүтээгдэхүүн нь эрдэс бүтээгдэхүүний экспортын **98.5** хувь буюу нийт экспортын **82.6** хувийг эзлэж байна.

Эрдэс бүтээгдэхүүний экспорт

№	Үзүүлэлт	Хэмжих нэгж	2018 I-VII		2019 I-VII		Өөрчлөлт			
			Тоо хэмжээ	Үнийн дүн	Тоо хэмжээ	Үнийн дүн	Тоо хэмжээ	Хувь	Үнийн дүн	Хувь
1	Чулуун нүүрс	сая тн/сая \$	20.55	1,610.7	20.81	1,787.9	0.26	1.3%	177.2	11.0%
2	Зэсийн хүдэр, баяжмал	мян.тн/сая \$	848.15	1,176.1	867.75	1,199.9	19.60	2.3%	23.8	2.0%
3	Боловсруулаагүй нефть	сая бар/сая \$	3.85	251.0	3.73	210.6	-0.13	-3.2%	-40.5	-16.1%
4	Төмрийн хүдэр, баяжмал	сая тн/сая \$	3.96	181.4	4.83	311.3	0.87	22.1%	129.9	71.6%
5	Хайлуур жонш	мян.тн/сая \$	239.92	79.4	359.08	114.9	119.16	49.7%	35.5	44.7%
6	Цайрын хүдэр, баяжмал	мян.тн/сая \$	71.30	123.7	82.75	121.5	11.45	16.1%	-2.2	-1.8%
7	Молибдений хүдэр, баяжмал	мян.тн/сая \$	3.36	26.9	3.30	29.1	-0.06	-1.7%	2.2	8.1%
8	Хар тугалганы хүдэр, баяжмал	мян.тн/сая \$	11.14	28.8	14.06	30.5	2.91	26.1%	1.8	6.1%
9	Цагаан тугалганы хүдэр, баяжмал	тн/сая \$	25.09	0.3	39.13	0.6	14.04	56.0%	0.3	84.2%
10	Гянтболдын хүдэр, баяжмал	тн/сая \$	289.38	3.3	275.23	2.9	-14.15	-4.9%	-0.4	-12.0%
11	Боловсруулаагүй буюу хагас боловсруулсан алт	тн/сая \$	3.43	144.5	4.67	195.9	1.23	35.9%	51.4	35.6%

Эх сурвалж: ГЕГ

Чулуун нүүрсний экспорт 2019 оны эхний 7 сард **1,787.9** сая ам.долларын **20.8** сая тн нүүрс экспортолсоныг өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад үнийн дүнгээр **177.2** сая ам.доллараар, тоо хэмжээний хувьд **257.8** мян.тн-оор тус тус их байна. 2018 оны мөн үед 1 тн нүүрсний хилийн дундаж үнэ **78.4** ам.доллар байсан бол энэ онд **85.9** ам.доллар болж өсчээ. Чулуун нүүрсний **98.0%**-ийг БНХАУ руу гаргасан байна.

Зэсийн баяжмалын экспорт 2019 оны эхний 7 сард **867.7** мян.тн-ыг экспортолсон нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад үнийн дүнгээр **23.8** сая ам.доллараар, тоо хэмжээний хувьд **19.6** мян.тн-оор тус тус их байна. Гэвч 2018 оны эхний 7 сард зэсийн баяжмалын экспорт үнийн дүнгээр **1,386.7** сая ам.доллар байсан бол тайлант сард **10,382.8** сая ам.доллар болжээ.

Төмрийн хүдрийн экспорт 2019 оны эхний 7 сард **4,834.7** мян.тн буюу **311.3** сая ам.долларт хүрсэн байна. 2018 оны мөн үеийн гүйцэтгэлтэй харьцуулахад уг бүтээгдэхүүний экспорт **874.2** мян.тн-оор, үнийн дүн нь **129.9** сая ам.доллараар тус тус өсчээ. 1 тн төмрийн

хүдрийн экспортын дундаж үнэ **64.4** ам.доллар болж, өнгөрсөн оны мөн үеийнхээс **18.6** ам.доллараар өссөн байна.

Боловсруулаагүй нефтийн экспорт 2019 оны эхний 7 сард **3,725.9** мян.бар буюу **210.6** сая ам.долларт хүрсэн нь өнгөрсөн оны мөн үеийн гүйцэтгэлээс **125.2** мян.бар-иар, үнийн дүнгээр **40.5** сая ам.доллараар тус тус бага байна. 1 бар нефтийн хилийн дундаж үнэ **65.2** ам.доллар байсан бол тайланд хугацаанд **56.5** ам.доллар болж буурчээ.

Цайрын баяжмалын экспорт 2019 оны эхний 7 сард **82.8** мян.тн цайрын баяжмалын 1 тн-ыг дунджаар **1,468.5** ам.доллараар экспортолсон байна. Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад хилийн дундаж үнэ **266.9** ам.доллараар буурсан байна. Цайрын баяжмалын экспорт үнийн дүнгээр **121.5** сая ам.доллар болж, өнгөрсөн оныхоос **2.2** сая ам.доллараар буурчээ.

Хайлуур жоншны экспорт 2019 оны эхний 7 сард **114.9** сая ам.долларын **359.1** мян.тн жонш экспортолсон нь 2018 оны мөн үеийн гүйцэтгэлээс **119.2** мян.тн-оор, үнийн дүнгээр **35.5** сая ам.доллараар тус тус өссөн байна. Жоншны экспортын дундаж үнэ **319.9** ам.доллар болж, өнгөрсөн оны мөн үеийнхээс **10.9** ам.доллараар буурсан байна. Хайлуур жоншийг БНХАУ, ОХУ, БНСУ руу экспортолсон ба 29.6%-ийг ОХУ-д, 70.1%-ийг БНХАУ-д тус тус ногдож байна.

Молибдений баяжмалын экспорт 2019 оны эхний 7 сард **29.1** сая ам.доллар болж, өнгөрсөн оны мөн үеийнхээс **2.1** сая ам.доллараар өссөн байна. Тус бүтээгдэхүүний 1 тн-ны экспортын хилийн дундаж үнэ **8,015.5** ам.доллараас **8,814.7** ам.долларт хүрч, **799.26** ам.доллараар өсчээ. 2019 оны эхний 7 сард **3,303.06** тн-ыг экспортолсон нь өнгөрсөн оны мөн үеэс **57.8** тн-оор бага байна. Молибдений баяжмалын 70.2%-ийг БНХАУ руу гаргасан байна.

Алтны экспорт 2019 оны эхний 7 сард **4,665.2** кг алт экспортолсон нь өнгөрсөн оны мөн үеийнхээс **1,233.3** кг-аар их байна. Алтны экспортын дундаж үнэ 2018 оны мөн үед **42,104.9** ам.доллар байсан бол энэ онд **41,998.0** ам.доллар болж **106.9** ам.доллараар багассан байна. Алтны экспорт үнийн дүнгээр **195.9** сая ам.долларт хүрч өмнөх оны мөн үеэс **51.4** сая ам.доллараар өсчээ.

3.2. ИМПОРТ

Импорт **3.5** тэрбум ам.долларт хүрч өнгөрсөн оны мөн үеийнхээс **241.6 (7.4%)** сая ам.доллараар өссөн байна.

Эрдэс бүтээгдэхүүний импорт **778.2** сая ам.доллар болж, өнгөрсөн оны мөн үеэс **47.8** сая ам.доллараар буюу **6.5%**-иар өссөн байна. Эрдэс бүтээгдэхүүний импортын **84.8%**-ийг нефтийн бүтээгдэхүүн эзлэж байна. 2019 оны эхний 7 сард **659.7** сая ам.долларын **1,045.2** мян.тн нефтийн бүтээгдэхүүн импортолсон нь өнгөрсөн оны мөн үеийнхээс **157.6** мян.тн-оор, үнийн дүнгээр **55.7** сая ам.доллараар тус тус өсчээ. Нефтийн бүтээгдэхүүний импортын **88.7%**-ийг автобензин, дизель түлшний импорт, үүний **31.8** хувийг автобензин, **68.2** хувийг дизель түлшний импорт эзлэж байна.

Автобензины импорт 2019 оны эхний 7 сард **1,045.2** мян.тн автобензин импортолсон нь 2018 оны мөн үеийн дүнгээс **157.6** мян.тн-оор их байна. 2018 оны мөн үед 1 тн автобензины импортын дундаж үнэ **693.9** ам.доллар байсан бол 2019 оны эхний 7 сард **594.6** ам.доллар болж **14.3%**-иар буурсан байна.

Дизель түлшний импорт 2019 оны эхний 7 сард **641.9** мян.тн болж 2018 оны мөн үеийн гүйцэтгэлээс **155.3** мян.тн-оор өссөн байна. 2018 оны эхний 7 сард 1 тн дизель түлшний импортын дундаж үнэ **651.1** ам.доллар байсан бол 2019 онд **622.0** ам.долларт хүрч **29.1** ам.доллар буюу **4.5** хувиар буурсан байна. Дизелийн түлшний импорт өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад **82.5** сая ам.доллараар нэмэгджээ.

--- оОо ---